

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА-II ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 05


Улаанбаатар
хот

Төсөл хэрэгжүүлэх
зааврууд батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан Тогтвортой амьжиргаа-II төслийн “Санхүүжилтийн гэрээ”-ний 2 дугаар хуваарийн I бүлгийн 3 дугаар зүйлийг үндэслэн, Дэлхийн банктай урьдчилан зөвшилцсөнөөр ТОГТООХ нь:

1. Тогтвортой амьжиргаа-II төслийн “Ерөнхий заавар”-ыг 1 дүгээр хавсралт, “Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлага бүрэлдэхүүн хэсгийн заавар”-ыг 2 дугаар хавсралт, “Олон нийтийн санаачилга бүрэлдэхүүн хэсгийн заавар”-ыг 3 дугаар хавсралт, “Бичил санхүүгийн хөгжил бүрэлдэхүүн хэсгийн заавар”-ыг 4 дүгээр хавсралт, “Хяналт шинжилгээ ба үнэлгээний заавар”-ыг 5 дугаар хавсралт, “Санхүүгийн удирдлагын заавар”-ыг 6 дугаар хавсралт, “Худалдан авах ажиллагааны заавар”-ыг 7 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Тогтвортой амьжиргаа-II төслийг хэрэгжүүлэх явцад батлагдсан заавруудыг чанд мөрдөн ажиллахыг Тогтвортой амьжиргаа-II төслийн газрын захирал/А.Хашцэцэг/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА,
САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.Баттөр

Д.БАТТӨР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.Золзаяа

Ц.ЗОЛЗАЯА